



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 05 сарын 20 өдөр

Дугаар А/98

Улаанбаатар хот

Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах
иргэдийг элсүүлэх, албанаас халах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Цэргийн албаны тухай хуулийн 30 дугаар зүйл, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Засгийн газрын 2018 оны 80 дугаар тогтоол, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.5 дахь заалт, нийслэлийн Засаг даргын 2025 оны А/463 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Цэргийн албыг биеэр дүйцүүлэх албанд 2025-2027 онд алба хаахаар хүсэлт гаргасан иргэдтэй гэрээ байгуулж, алба хаах хугацаанд үүрэг чиглэлээр ханган гүйцэтгэлд нь хяналт тавьж, ажиллахыг Цэргийн штабт (хурандаа Ш.Бат-Өлзий)-т үүрэг болгосугай

2.Цэргийн албыг биеэр дүйцүүлэх албанд элссэн иргэдийн нэрийн жагсаалтыг нэгдүгээр, 2023-2025 онд Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж, хугацаа дуусан иргэдийг халах, Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах журам, байгуулсан гэрээ зөрчсөн иргэдтэй гэрээг цуцлах нэрийн жагсаалтыг хоёрдугаар, Цэргийн албыг биеэр дүйцүүлэх албанд элссэн иргэдийн үүрэг гүйцэтгэхэд шаардлагатай хувцас тусгай хэрэглэлийн зардлыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Шаардагдах 4,200,000 (Дөрвөн сая хоёр зуун мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.


4.Үйл ажиллагааг зохион байгуулж дуусанаас хойш ажлын 5 хоногийн дотор тайланг танилцуулж зарцуулсан санхүүгийн тайланг ирүүлэхийг Цэргийн штаб (хурандаа Ш.Бат-Өлзий)-т, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг Засаг даргын Тамгын газар (Л.Санжийжамц)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2025 оны дүгээр сарын-ны өдрийн
А/М... дугаар захирамжийн гуравдугаар хавсралт



ЦЭРГИЙН АЛБЫГ БИЕЭР ДҮЙЦҮҮЛЭХ АЛБАНД
ИРГЭДИЙН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭХЭД ШААРДЛАГАТАЙ ХУВЦАС
ТУСГАЙ ХЭРЭГСЛИЙН ЗАРДЛЫН ТООЦОО

д/д	Хувцас хэрэглэлийн нэршил	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	нийт үнэ
1	Малгай (зуны саравчтай)	6 ширхэг	25,000	150,000
2	Китель өмд \зуны)	6 хос	180,000	1,080,000
3	Гутал (зуны)	6 хос	170,000	1,020,000
4	Цэрэг бүс	6 ширхэг	80,000	480,000
5	Футболк	6 ширхэг	30,000	180,000
6	Ноосон цамц	6 ширхэг	80,000	480,000
7	Нэр (алба хаагчийн)	12 ширхэг	10,000	120,000
8	Ханцуйн тэмдэг (дүүргийн лого)	12 ширхэг	10,000	120,000
9	Ханцуйн тэмдэг (Цэргийн штаб лого)	12 ширхэг	10,000	120,000
10	Албаны нэр	12 ширхэг	10,000	120,000
11	Малгайн тэмдэг	6 ширхэг	10,000	60,000
12	Хөдөлмөр хамгааллын каск	6 ширхэг	25,000	150,000
13	Тусгай зориулалтын бээлий	6 ширхэг	20,000	120,000
Нийт				4,200,000